



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот


“Багануур Үйлдвэрлэл, технологийн парк”
орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж” заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Багануур дүүргийн нутаг дэвсгэрт Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2. “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын орон тоог баталж, санхүүжилтийн болон бусад шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТТУЛГА

1110100354

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны
өдрийн 122 дугаар тогтоолын хавсралт

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь /цаашид ОНӨТҮГ гэх/ Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт парк байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий газар юм.

1.2. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж, үйл ажиллагааны хөтөлбөр, холбогдох бусад хууль, тогтоомжууд болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Энэ дүрмийн зорилго нь Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх болон бусад харилцааг хууль тогтоомжинд нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь тогтоосон журмын дагуу хийгдсэн бэлгэдэл, тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, нийслэлийн төрийн сан банкинд харилцах данстай байна.

1.5. Тэмдгээр Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ гэсэн албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

1.6. Тэмдгийг газрын даргын тушаалаар итгэмжлэгдсэн албан тушаалтан хариуцан түшиж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

1.7. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газраас тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлж ажиллах бөгөөд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид ажлаа тайлагнана.

Хоёр. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь нийгэм эдийн засаг, байгаль орчны зохистой харьцааг хангах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар, төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;

2.2. Хариуцсан ажил үүргийн чиглэлээр паркийн бүсийг хөгжүүлэх, төлөвлөх, орчноо тохижуулах үйл ажиллагаанд хувийн хэвшил, холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог ханган, тэдний санал санаачлагыг хөгжлийн төсөл, хөтөлбөрт тусгах, хамтран ажиллах;

2.3. Үйлдвэрлэл, технологийн паркийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг нарийвчилж тооцсон хөгжлийн үе шатны төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг тооцон Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын Удирдах зөвлөлөөр оруулж батлуулах;

2.4. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг хангах нарийвчилсан төлөвлөгөө гарган Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;

2.5. Тухайн олгогдсон газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг бий болгох саналыг боловсруулах;

2.6. Хувийн хэвшлийг түлхүү оролцуулж концессын гэрээгээр дэд бүтцийн байгууламжийг барьж байгуулах асуудлыг судалж, холбогдох Нийслэлийн захиргааны байгууллагад санал оруулах;

2.7. Паркийн дэд бүтцийн техникийн нөхцлүүдийг нарийвчлан судалж, холбогдох бичиг баримт материалууд, зураг, схемүүдийг бүрдүүлж, паркийн эрчим хүч, дулаан, усан хангамж зэргийн хэрэглээний нийт тооцоог гаргаж, хот байгуулалт, инженерийн байгууламжийн төлөвлөгөөтэй уялдуулан инженерийн тооцоо зураглал боловсруулах ажлыг зохион байгуулах;

2.8. Хуульд зааснаар паркт байрлах аж ахуйн нэгжүүдийг батлагдсан чиглэлийн дагуу дээд байгууллагуудтай хамтран сонгон шалгаруулах;

2.9. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийг баримтлах;

2.10. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх талаар гаргасан хууль, тогтоомж, шийдвэр, төлөвлөсөн бодлого, авч буй арга хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, түүний үр дүнгийн талаар олон нийтэд сурталчлах;

2.11. Гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож ажиллах;

Гурав. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын эрх, үүрэг

3.1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь дор дурдсан эрхтэй байна.

3.1.1. Байгууллагын санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, төсөв болон үйл ажиллагааны орлогыг дүрэмд заасан үйл ажиллагаа, батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор зарцуулах;

3.1.2. Эрхлэх ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах асуудлаар шийдвэрийн төсөл, санал боловсруулж холбогдох байгууллагад уламжлах;

3.1.3. Төсөл хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч нартай өөрийн эрхлэх ажлын чиг үүрэг, олгогдсон эрх хэмжээний хүрээнд гэрээ байгуулах;

3.1.4. Зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ажлыг мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх;

3.1.5. Төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгууллагын стратеги төлөвлөгөөний дагуу өөрийн үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулах;

3.1.6. Үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажилтай холбоотой шаардлагатай бичиг баримт, мэдээ, мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авах;

3.2. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь дор дурдсан үүрэгтэй байна.

3.2.1. Парк хөгжүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллах;

3.2.2. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн бүсэд нарийвчилсан судалгаа, дүгнэлт хийж, паркийг байгуулах хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулахад санал өгөн ажиллах;

3.2.3. Монгол Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын захирамж, тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гаргах;

3.2.4. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь боловсруулсан төсөл, хөтөлбөрөө Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газарт танилцуулах;

3.2.5. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь үйл ажиллагааны хэтийн болон жилийн төлөвлөгөөтэй ажиллаж, түүний биелэлтийг Нийслэлийн Засаг Даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчид танилцуулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид тайлагнах;

3.2.6. Бусад хууль, тогтоомжоор олгогдсон үүргийг хэрэгжүүлж ажиллах.

Дөрөв. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын удирдлага

4.1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдана. Даргыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон

хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

4.2. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан байна.

4.3. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

4.4. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай болон Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчтой үр дүнгийн гэрээ, Нийслэлийн Өмчийн харилцааны газартай контрактын гэрээ байгуулан жилээр дүгнэн ажиллана.

4.5. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч баталж, орон тооны хязгаарт Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар хяналт тавина.

Тав. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын эрх, үүрэг

5.1. Дарга нь доорхи эрх, үүрэг хүлээнэ.

5.1.1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрийн газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажил зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

5.1.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэгжийн үйл ажиллагааг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого явуулах;

5.1.3. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь Үйлдвэрийн газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах;

5.1.4. Ажил үйлчилгээ гүйцэтгэж явахад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ажиллахгүй байх;

5.1.5. Нийслэлийн Засаг даргын батласан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтэц батлах, цалингийн хэмжээ, урамшуулалын журам, дотоод журмыг тогтоож мөрдүүлэх, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх;

5.1.6. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь шинээр худалдаж авах, болон акталж устгах, худалдах, шилжүүлэх хөрөнгийн асуудлыг Өмчийн харилцааны газарт тавьж шийдвэрлүүлэх;

5.1.7. Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч болон Өмчийн харилцааны газраас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, үйлдвэрийн газрыг төлөөлөх зэргээр үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;

5.1.8. Эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргах;

5.1.9. Дарга өөрийн эрх үүргийг нийслэлийн Засаг дарга болон холбогдох бусад газартай зөвшилцөж итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрх, үүргээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй;

5.1.10. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ орон тооны дээд хязгаар, бүтцийг Техник эдийн засгийн үндэслэлийн тайланд тусгасан үйл ажиллагааны цар хүрээнд үндэслэн Нийслэлийн Засаг дарга тогтоож, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга орон тооны дээд хязгаарт багтаан ажилтнуудыг ажилд томилж, ажлаас чөлөөлөх;

5.1.11. Ажилтнуудтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах бөгөөд дотоод журам болон гэрээгээр тогтоосон эрх хэмжээний хүрээнд Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах;

5.1.12. Дарга нь урт хугацааны сургалтад хамрагдсан, чөлөөтэй, томилолттой байх хугацаанд хууль тогтоомж, дүрэм журмын дагуу түүний эрх үүргийг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын түр орлон гүйцэтгэгч хэрэгжүүлнэ. Түр орлон гүйцэтгэгчийг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын тушаалаар томилно/

5.1.13. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч ажиллахдаа хүний нөөцийн болон хөрөнгө санхүүтэй холбогдолтой тушаал гаргах, ОНӨТҮГ-т мөрдөн ажиллаж байгаа дүрэм, журамд өөрчлөлт оруулахаас бусад эрх үүргийг бүрэн хэрэгжүүлнэ.

Зургаа. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Удирдах Зөвлөл

6.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Журам гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай” 54 дүгээр тогтоолын дагуу Удирдах зөвлөлийг томилон, журманд заасны дагуу Удирдах зөвлөл үйл ажиллагаагаа явуулна.

Долоо. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Санхүү, аж ахуйн үйл ажиллагаа

7.1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны зардлыг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

7.2. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

7.3. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.

7.4. Санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулж болно.

7.5. Санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана. Үүнд:

7.5.1. Баланс;

7.5.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

7.5.3. Мөнгөн гүйлгээний тайлан;

7.5.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан;

7.5.5. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин шагнал, урамшуулал;

7.5.6. Нэмэлт тайлбар;

7.5.7. Санхүүгийн тайлангийн тодруулга;

7.5.8 Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

7.6. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайланг хүргүүлнэ. Үүнд:

7.6.1 Тайлангийн хугацаанд эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

7.6.2. Тайлангийн хугацаанд ажилчин, албан хаагчдад олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ;

7.6.3. Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.

7.7. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Контрактын биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлэн, Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газарт ирүүлнэ.

Найм. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах

8.1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь дараах баримт бичгийг хадгална.

8.1.1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, газар байгуулах тухай холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд;

8.1.2. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд;

8.1.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

8.1.4. Үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, холбогдох бусад баримт бичгүүд;

8.1.5. Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын тушаал, шийдвэрүүд;

8.1.6. Бусад ач холбогдол бүхий баримт бичгүүд.

8.2. Дээрх баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох ажилтан, албан хаагчаас хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд захирлын шийдвэрээр танилцуулах, архивт шилжүүлэх ажлыг бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

Ес. “Багануур үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг татан буулгах

9.1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ыг Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу удирдах дээд байгууллага татан буулгана.

Арав. Хариуцлага

10.1. Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол буруутай этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.2. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ыг оноосон нэр, бэлэгдэл /эмблем/-ийг зөвшөөрөлгүй ашигласан аж ахуйн нэгж, байгууллага иргэнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Арван нэг. Бусад

11.1. Хуульд нийцүүлэн энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

11.2. Энэ дүрэм нь Монгол улсын Бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

--- х Х х ---